

2018 оны 10 сарын 26 өдөр

№ 2018/14

Улаанбаатар хот

## Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.17, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1.1 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Централ Секюритиз УЦК” ХХК болон “Инвекор капитал УЦК” ХХК-ийг тус тус “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Централ Секюритиз УЦК” ХХК болон “Инвекор капитал УЦК” ХХК -тай “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг компанийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Централ Секюритиз УЦК” ХХК /Д.Баярсайхан/ болон “Инвекор капитал УЦК” ХХК /Р.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.
4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.БАТХУЯГ